



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01/А

Улаанбаатар хот

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ОРОН ТОО,  
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ, "ДОТООД ЖУРАМ"  
ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, Боловсрол Соёл шинжлэх ухааны сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан 2011 оны "Санамж бичиг", "Нийслэлийн Соёл урлагийн газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" Нийслэлийн Засаг даргын 2011 оны 516 дугаар, 2009 оны 608 дугаар захирамжаар тус тус батлагдсан газрын дүрмийн 2.2 дахь заалт үндэслэн ТУШААХ НЬ:

1. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан газрын бүтэц, орон тоо нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, "Дотоод журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. "Дотоод журам"-ыг чанд мөрдөн хэрэгжүүлж ажиллахыг төрийн албан хаагчид, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

3. Бүтэц, орон тоо, ажил үүргийн хуваарь шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, үр дүнгийн гэрээ байгуулахыг хүний нөөц, киноны асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д үүрэг болгосугай.

4. Төрийн албаны тухай хуулийн дагуу шинэ ажлын байрыг нийтэд мэдээлэх, нөөцөд байгаа ажилтнуудыг судлах, бүртгүүлсэн хүмүүстэй ярилцлага зохион байгуулж, нэн шаардлагатай ажлын байранд түр ажиллуулах ажилтны тухай саналаа анкетийн дагуу танилцуулахыг ахлах мэргэжилтэн /Д.Мэндсайхан/-д даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Тус газрын даргын 2011 оны 01 дүгээр сарн 17-ны өдрийн "Дотосд журам батлах тухай" 02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

05

Ц.Пүрэвхүү 2012 оны 01 сарын 03-р хүчингүй

ДАРГА

*[Handwritten signature]*

Ц.ПҮРЭВХҮҮ

111050000001  
Тушаал 2012



15

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 5/05

Улаанбаатар хот

ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ  
ТУХАЙ

Монгол улсын Засгийн газрын 2012 оны "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 78 дугаар тушаалын 1,8 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус газрын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хавсралтын дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Албан хаагчдын шинэчлэн тогтоосон цалинг хавсралтын дагуу 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг ня-бо / О.Эрдэнэцэцэг / -д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл урлагийн газрын даргын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 18.6 дугаарын тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Ц.ПҮРЭВХҮҮ

Төрийн даргын 2012 оны 01 сарын 03 А/01-р хүчингүй тушаал

11105000046



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот


Дүүргүүдийн соёлын ордны  
бүтэц орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн хүн амын төвлөрлөөс шалтгаалан иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дүүргүүдийн соёлын төвүүдийг соёлын ордон болгон өргөтгөж үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан дүүргүүдийн Соёлын ордны бүтэц зохион байгуулалтын ерөнхий загварыг нэгдүгээр, орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Байгууллагынхаа бүтэц, орон тоо, албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолт, цалингийн санг шинэчлэн батлаж дараа жилүүдийн төсвийн төсөл төсөөллүүдэд тусгаж ажиллахыг дүүргүүдийн соёлын ордны захирлуудад үүрэг болгосугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг тус газрын нийтийн соёл, соёлын төв, статистик хариуцсан мэргэжилтэн / С.Дэлгэрмаа/-д даалгасугай.



ДАРГА

Ц. ПҮРЭВХҮҮ

Төрийн дарга 2011.01.25-ны тушаалыг -р хүчингүй

Tushaal 2011

11105000009

27

111050000049

31



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 44.

Улаанбаатар хот

ДОТООД ЖУРАМ ШИНЭЧЛЭН  
БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай хуулиуд, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 608 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай

Хоёр. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан дотоод журам батлах тухай Соёл урлагийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ц.ПҮРЭВХҮҮ

*Цурч дарга 2011.01.08 нд №02 тушаал р хүчингүй*

Tushaal 2009

05 081

32



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


ДОТООД ЖУРАМ ШИНЭЧЛЭН  
БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай хуулиудын зарим заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг 2008 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс мөрдлөг болгон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл урлагийн газрын дотоод журам батлах тухай соёл урлагийн газрын 2005 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ц.ПҮРЭВХҮҮ

Соёл урлагийн газрын 2008 оны 11 дүгээр сарын 4-р хүчингүй  
тушаал

My.dok.2008.tushaal

05 003

49



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2005 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ДОТООД ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Засаг даргын 2005 оны 78 тоот захирамжаар батлагдсан газрын дүрмийн 2.2 заалтыг үндэслэн ТУШААХ нь

**Нэг.** Тус газрын хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтын дагуу баталсугай.

**Хоёр.** Хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрдөн ажиллахыг ажилтнуудад даалгасугай.

**Гурав.** Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Соёлын газрын даргын 2001 оны 11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ц.ПҮРЭВХҮҮ

1/16/2005 оны 01-р 18-ийн № 02-р хүчингүй  
Түгээгч

D:\My Documents\2005\Tyshaal\13.doc

05 001

50



24

### СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2006 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

#### ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 147 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

**Нэг.** Тус газрын ажилтнуудын сарын цалинг төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний дагуу шинэчлэн тогтоож 1 дүгээр хавсралтаар батласугай.

**Хоёр.** Энэхүү тушаалыг 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж ажилтнуудын цалин хөлсний зөрүүг бодож олгохыг ня-бо /О.Эрдэнэцэцэг/-т зөвшөөрсүгэй.

**Гурав.** Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2006 оны 04 дүгээр тушаал түүний хавсралтыг хүчингүй болсонд тооцугай.



*Handwritten signature*

Ц. ПҮРЭВХҮҮ

1069/н. 2009.14 -ны 2002 оны 01 -р 19-нн 15.01 -р хүчингүй  
Гарсан



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2005 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

АЖЛААС ЧӨЛӨӨЛЖ, АЖИЛД ТОМИЛОН  
ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчлэгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" 94 дүгээр, 2004 оны 42, 2005 оны 15 дугаар тогтоолын 4 дүгээр заалт, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 28 дугаар захирамжийн 4 дүгээр заалт, 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

**Нэг.** Бүтцийг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан Соёлын газрын мэргэжилтэн С.Жимээхүү, С.Дэлгэрмаа, Д.Энхчимэг С.Насанбат, Архив бичиг хэргийн эрхлэгч, даргын туслах С.Оюунчимэг нарыг 2005 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс тасалбар болгон тус тус чөлөөлсүгэй.

**Хоёр.** Соёл, урлагийн газрын ажилтнуудыг 2005 оны 04 дугаар сарын 1-ний өдрөөс томилон ажиллуулж, албан тушаал, сарын үндсэн цалин, нэмэгдлийг хавсралт ёсоор олгохыг ня-бо /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

**Гурав.** Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёлын газрын даргын 2004 оны 3 дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар тушаал болон түүний хавсралтаар тогтоосон цалин нэмэгдлийг хүчингүй болсонд тооцсугай.

УХА0202  
ДАРГА

*Ц.Пүрэвхүү*

Ц.ПҮРЭВХҮҮ

10 дугаар сарын 14-ны 2005 оны 02-р 13-ны 04-р хүчингүй

С:\My Documents\2005\Tyshaal8.doc

05 009  
57





6

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2006 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ, АЖИЛД  
ТОМИЛОХ, АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ  
КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2005оны 94, 2002 оны 195, 2006 оны 12 дугаар тогтоолуудыг үндэслэн ТУШААХ нь:

**Нэг.** Тус газрын Хүний нөөц, архив, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэнээр Аюушийн Хишигдаваа, Соёлын өв, аялал жуучлал, мэдээлэл сурталчилгаа, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэнээр Батжаргалын Ганхөлөг нарыг 2006 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.


**Хоёр.** Тус газрын ажилтнуудын цалинг Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний дагуу шинэчлэн 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 1 дүгээр хавсралтаар баталсугай.

**Гурав.** Тус газрын мэргэжилтнүүдийн ажил хүлээлцэх комиссыг 2006 оны 2 дугаар сарын 15-ны өдөр доорх комиссын бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга  
Гишүүд

С.Жимээхүү	- Ахлах мэргэжилтэн
С.Оюунчимэг	- мэргэжилтэн
Д.Мэндсайхан	- мэргэжилтэн
С.Дэлгэрмаа	- мэргэжилтэн
О.Эрдэнэцэцэг	- байгууллагын ахлах ня-бо

**Дөрөв.** Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, урлагийн газрын даргын 2005 оны 6 дугаар тушаал түүний хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай



100р-ийн дэргэд нь 2006 оны 08-р 15-ны 18-р хүчингүй  
тушаал өгөх

ДАРГА  Ц. ПҮРЭВХҮҮ



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2004 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 07


Улаанбаатар хот

ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчлээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" 94 дүгээр, 2004 оны "Төрийн албан хаагчийн цалингийн талаарх авах арга хэмжээний тухай" 42 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Тус газрын ажилтнуудын албан тушаалын цалин, нэмэгдлийг хавсралтаар шинэчлэн тогтоож, 2004 оны 2 дугаар сарын 15-наас тооцож олгосугай.

Хоёр. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Соёлын газрын даргын 2004 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тушаал болон түүний хавсралтаар тогтоосон цалин нэмэгдлийг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ц.ЭНХБАТ

2004 оны 3 сарын 15 өдөр 07 дугаар №06-р хүчингүй  
тушаал

C:\My Documents\2004\Tyshaal\8.doc

05.013



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2007 оны 01 сар 27 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Дотоод журам батлах тухай

Газрын дүрмийн 1.5 дугаар заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Тус газрын дотоод журмыг хэвсгалтын дагуу баталсугай.
2. Журмыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрдөн ажиллахыг ажилтнуудад даалгасугай.



ДАРГА

Г.НЯМСАМБУУ

Газрын дарга-ны аас 03-р 11-н 03-р хүчингүй

түмээгээр





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СОЁЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2003 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01


Улаанбаатар хот

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 195 дугаар тогтоолын 1,4 дүгээр хавсралтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын ажилтнуудын сарын цалингийн хэмжээг дээрх тогтоолын дагуу тогтоож, 2003 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хавсралт ёсоор олгохыг ня-бо (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2002 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн 35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай



ДАРГА

Ц.ЭНХБАТ

Tushaal-2003

Тус газрын даргын 2002 оны 10-р сарын 03-ны № 35-р хүчингүй  
тушаал

05 001



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СОЁЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2002 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Цалин шинэчлэлт тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 195 дугаар тогтоолын 1,4 дүгээр хавсралтуудын үндсэн дээр гаргасан ТУШААХ нь:

1. Тус газрын ажилтнуудын сарын цалин хэмжээг дээрх тогтоолын дагуу тогтоож, 2002 оны 10 дугаар сарын 1-н өдөр эхлэн хавсралт ёсоор олгохыг ня-бо (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдох зардлыг газрын даргын 2002 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот тушаалын хүрээнд хөрөнгө болгосонд тооцсугай.



ДАРГА

Ц.ЭНХБАТ

Газрын даргын тушаал нь 2003 оны 01-р 13-нө № 01-р хүчингүй

№ 5 0071



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СОЁЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2002 оны 01 сарын 14 өдөр


Дугаар 01

Улаанбаатар хот

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын "Төрийн албан хаагчдийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 2001 оны 232 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Санхүү эдийн засгийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын "Тушаалын заалтад өөрчлөлт оруулах тухай" хамтарсан 296/96 дугаар тушаалын 2 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын газрын ажилтнуудын сарын цалинг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.
2. Тус газрын ажилтнуудын сарын цалинг 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хавсралтын дагуу олгохыг ня-бо (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 33 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.



ДАРГА

Ц.ЭНХБАТ

105р-14 дугаар 24-нь 2002 оны 10-р сарын 15-р хүчингүй



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

60

2001 оны 11 сар 27 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 232 дугаар тогтоол, Монгол Улсын Сөнхүү эдийн засгийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан 296/96 тоот тушаалын 2 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын газрын ажилтнуудын цалинг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2001 оны 01 тоот тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.
3. Энэ тушаалд хамаарах тус газрын албан хаагчдын шинэчилсэн цалинг 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг ня-бо (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Г.НЯМСАМБУУ

Тайрмал 2001 оны 01-р 14-нн № 01-р хүчингүй

Григорьев

67.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

3

2001 оны 01 сар 05 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

(алин шинэчлэн тогтоо) тухай

Монгол Улсын Засгийн газрын 1000 оны 12 дугаар сарын 29-ний  
өднийн 294 дүгээр тогтоолын 1.4 дүгээр дараах түүнийг үндэслэн  
ТУШААХ нь:


1. ХС газрын өмчлөхүүдийн сөрөг цахим 2001 оны 1 дүгээр сарын 1-  
ний өдрөөс эхлэн хөвсрэлтын дагуу олгохыг ня бо (Уламчимэг)-д  
илгээгдэж үгэй.

2. Энэ тушаал гарманы өдөрөөс эхлэн тус газрын даргын 2000 оны 1  
дүгээр сарын 02-ний өдрийн 01-ний тухайн үүсгэн байгууллыг



*[Handwritten signature]*

Г.НУМСАМБУ



Газрын даргын 2001 оны 12-р 27-нө № 33-р хүчингүй  
тушаал





1.

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2000 оны 01 сар 03 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

1. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 1,4 дүгээр хавсралтуудыг үндэслэн тус газрын ажилтнуудын сарын цалинг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хавсралтын дагуу шинэчлэн тогтоож олгохыг ня-бо (н. Батнасан)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 1999 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 34 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.



ДАРГА

Г.НЯМСАМБУУ

1999 оны 12 сарын 29-ны өдрийн 224-р тогтоолын 1.4-дүгээр хавсралтын дагуу шинэчлэн тогтоож олгохыг зөвшөөрсүгэй



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

1999 он 10 сар 4 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 1999 он 9 дүгээр сарын 22-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг үндэслэн тус газрын ажилтнуудын сарын цалинг 1999 он 10 дугаар сарын 1-ний өдрөөс хавсралтын дагуу шинэчлэн тогтоож олгохыг ня-бо /н.Батнасан/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Г.НЯМСАМБУУ

1999 он 10 сар 4-ны 2000-ны 01-р Огноо № 01-р хүчингүй

Тунхаг



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ОРОН ТОО,  
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРИЙГ БАТАЛЖ,  
ЦАЛИН ШИНЭЧЛЭН ТОГТООХ  
ТУХАЙ

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, "Нийслэлийн Соёл урлагийн газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" Нийслэлийн Засаг даргын 2011 оны 516 дугаар, 2009 оны 608 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 78 дугаар тогтоолын 1,8 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ НЬ:


1. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан газрын бүтэц, орон тоог нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, цалинг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Бүтэц, орон тоо, ажил үүргийн хуваарь шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, үр дүнгийн гэрээ байгуулахыг хүний нөөц, киноны асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж /-д үүрэг болгосугай.

3. Тус газрын албан хаагчдын албан тушаалын шинэчлэн тогтоосон үндсэн цалинг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгохыг ня-бо /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Байгууллагын бүтэц, орон тоо, ажил үүргийн хуваарь, дотоод журам батлах тухай" А/03 дугаар тушаалын 1 дэх заалтаар батлагдсан газрын бүтэц, орон тоо, ажил үүргийн хуваарийн хэсэг, мөн газрын даргын 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн цалин шинэчлэн тогтоох тухай 5/25 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



*(Handwritten signature)*

Ц.ПҮРЭВХҮҮ

111050000001

111050000001 2013 оны 01 сарын 03 өдөр Хүчингүй

*(Handwritten signature)*



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ДОТООД ЖУРАМ ШИНЭЧЛЭН  
БАТЛАХ ТУХАЙ


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Соёлын тухай хуулиуд, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 608 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай

Хоёр. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан дотоод журам батлах тухай Соёл урлагийн газрын 2009 оны 44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Ц.ПҮРЭВХҮҮ

Соёл урлагийн газрын 2009 оны 44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай



111050000049